



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 07 дугаар сарын 04-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-22</i>
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай/</i>	<i>6-10</i>
<i>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай</i>	<i>10-15</i>
<i>3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай/</i>	<i>15-16</i>
<i>4.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	<i>16-22</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 07 дугаар  
сарын 04-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 35 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, С.Цэдэндамба, мөн зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Удирдлагын академын захирал Д.Сүрэнчимэг, мөн академын Эрх зүйн тэнхмийн эрхлэгч, доктор А.Алтанзул, Монгол Улсын Их Сургуулийн зөвлөх профессор Р.Дарьхүү, мөн сургуулийн багш, дэд профессор П.Оюунгэрэл, Маргаан хянан шалгах газрын ахлах шинжээч С.Сарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Баттөмөр танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Удирдлагын академын Эрх зүйн тэнхмийн эрхлэгч, доктор А.Алтанзул, Монгол Улсын Их Сургуулийн багш, дэд профессор П.Оюунгэрэл нар хариулж, тайлбар хийв.

**Б.Баттөмөр:** “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

*Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, С.Цэдэндамба, мөн зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Удирдлагын академын захирал Д.Сүрэнчимэг, мөн академын Эрх зүйн тэнхмийн эрхлэгч, доктор А.Алтанзул, Монгол Улсын Их Сургуулийн зөвлөх профессор Р.Дарьхүү, мөн сургуулийн багш, дэд профессор П.Оюунгэрэл, Маргаан хянан шалгах газрын ахлах шинжээч С.Сарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Баттөмөр танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

**Б.Баттөмөр:** “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	2
Бүгд:	6

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

*Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Б.Баттөмөр танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Баттөмөр:** “Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Суудмаа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Т.Энхболд нар орж ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн шинжээч Т.Мөнгөнцэцэг, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн Захираа, удирдлагын хэлтсийн дарга В.Жавзан, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга З.Баасанням, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга З.Баасанням нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэхээр тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 51 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин  
Д.Сүхбаатар” танхим 09 цаг 27 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баттөмөр:** Байнгын хорооны хурлын ирц бүрдсэн байна. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье ээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх ирсэн тул Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Хурлын дарааллыг танилцуулна. Хуралдаанд оролцсон гишүүдийн ирцийг танилцуулъя. Баттөмөр байна, Адьшаа гишүүн байна, Баделхан байна, Бат-Эрдэнэ гишүүн байна, Бейсен гишүүн байна, Нямаагийн Энхболд гишүүн байна, Энхбаяр гишүүн гадаад томилолттой байгаа юм байна, Бямбацогт гишүүн гадаад томилолттой байна, Баярсайхан гишүүн нь өвчтэй байна.

Ингээд хурлын ирц бүрдсэн байна.

Дарааллыг танилцуулъя.

Дөрвөн асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт нь, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Засгийн газар 2023 оны 6 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Хоёрдугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл. Энд Ёс зүйн байнгын хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай,

Байнгын хорооны тогтоолын төсөл Ёс зүйн байнгын хорооны орон тооны бус гишүүнийг сонгож шалгаруулах журам батлах тухай,

Дөрөв дэх асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсэг байгуулах гэсэн ийм 4 асуудал хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Алга байна. Энэ Байнгын хороодуудын хурал давхцаж байна. Сангийн яам Аудитын газар Эдийн засгийн байнгын хороон дээр хуралдаж байгаа юм байна.

Байнгын хорооны тогтоолын төсөл Ёс зүйн байнгын хорооны үйл ажиллагааны дүрмийг батлах тухай энэ асуудлыг хэлэлцье. Хэн танилцуулах билээ? Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийг та бүгдэд тараачихсан байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хоёр дахь асуудал. Ёс зүйн хорооны дүрмийг батлах тухай асуудал хэлэлцэнэ.

Энэ дээр ажлын хэсгийн гишүүд суудлаа эзэлье.

Ажлын хэсэгт Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн дарга, Амартөгс Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Идэрчулуун Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Цэдэндамбаа Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Бат-Эрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Маргаан таслах газрын дарга, Дуламсүрэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга, Сувдмаа ЗГХЭГ-ын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан



үүргийг түр орлон гүйцэтгэгч, Алтанзул Удирдлагын академийн эрх зүйн танхимын эрхлэгч доктор, Дарьхүү МУИС-ийн зөвлөх профессор, Оюунгэрэл МУИС-ийн багш, дэд профессор, Сарангэрэл Маргаан хянан шалгах газрын ахлах шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байгаа.

Энэ нөгөө Байнгын хорооны тогтоолын төсөл. Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай та бүхэнд урьдчилж хүргүүлсэн байгаа. Цахимаар хүргүүлсэн, мөн цаасаар хүргүүлсэн байгаа.

Байнгын хорооны төсөл болон Ёс зүйн хорооны дүрмийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя.

Баделхан гишүүнд баярлалаа.

Ерөнхийдөө энэ ёс зүйн үйл ажиллагааны дүрмийг бол бид нар дэмжиж байгаа. Баделхан гишүүн.

**Х.Баделхан:** Тэгэхээр 1 асуулт бол энэ төрийн албан хаагч нарт энэ дүрэм үйлчилж байгаа. Гэтэл нөгөө ТӨК гэж бас нэг том байгууллага байгаа шүү дээ. Төрийн өмчит компаниуд байгаа, төрийн өмчийн оролцоотой компаниуд байгаа. Ер нь энэ хүмүүс ч гэсэн бас төрөөс бараг цалин авч байгаа төрийн албан хаагч нар шүү дээ. Тэгээд энэ хүмүүстээ энэ үйл ажиллагааны дүрэм үйлчлэх үү ер нь. Тэднийг ер нь бас төрийн албатай адилхан тооцоод ер нь цаашидаа бас ажлыг нь дүгнээд ёс суртахууны хувьд бас ер нь ажлыг нь дүгнэж байвал зүгээр байна гэсэн бодолтой байгаа л даа.

Тэгээд асуулт бол ТӨК-удын албан хаагч нарт энэ дүрэм үйлчлэх үү гэсэн асуулт байна. Баярлалаа.

**Б.Баттөмөр:** Баделхан гишүүний асуултад Удирдлагын академийн тэнхимийн эрхлэгч доктор Алтанзул 7 дугаар микрофон өгье.

**А.Алтанзул:** Гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчит хуулийн этгээд ТӨК, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнууд төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн үйлчлэлд хамаарна. манай энэ Ёс зүйн хорооны өнөөдрийн хуралдаанаар орж байгаа дүрэм маань нөгөө том хороо гэж ярьж байгаа. Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн орон тооны бус 4 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааных нь дүрэм байгаа.

Тэгэхээр энэ дүрмийн үйлчлэлд төрийн өндөр албан тушаалтнууд болон Авлигын эсрэг хуулийн тодорхой зүйл, заалтад хамаарах албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг энэ том хороо маань шийднэ. Түрүүн хэлсэн төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах ажилтнууд нь харьяалах дээд томилдог албан тушаалтан буюу Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын дэд хорооны ажиллах үйл ажиллагааны хүрээнд хамаарч байгаа.

**Б.Баттөмөр:** Дэд хороондоо харьяалагдаад явна. Бүх Монголын төрийн албаны 230 гаруй мянган төрийн албан хаагчид энэ Ёс зүй, сахилга хариуцлагын хууль маань үйлчилнэ ээ гэсэн ийм хариултыг өгч байна. Энэ дээр сая зарлаагүй Сүрэнчимэг ЗГХЭГ-ын дэргэдэх Удирдлагын академийн захирал Сүрэнчимэг ирсэн байна. Бусад хүмүүсийг бүгдийг нь зарлачихсан байгаа.

Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би 2 зүйл тодруулж асуух гээд байгаа юм. Нэг дүгээрт энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ажлын хэсэг дээр ахалсан, ажилласан эрдэмтэн судлаачид энэ ажлын хэсгийн хүмүүс та бүхэнд нэгдүгээрт баяр хүргэе.

Хоёрдугаарт бол энэ Удирдлагын академи МУИС энэ судалгааны хүрээлэнгүүд дээр ер нь энэ улс орнууд хөгжил дэвшилд хүрсэн ийм улс орнуудын



харьцуулсан судалгаа байдаг уу? Манайхтай адилхан нэг тогтолцооноос шинэ нийгмийн харилцаа руу шилжсэн ийм улс орнууд чинь бид нараас бүүр түрүүлээд яваад өгчихсөн ийм улс орнууд байна шүү дээ. Хөрш зэргэлдээ Станы улсууд гэж ярьдаг. Сая бид нар 4 жилд нэг удаа зохион байгуулагддаг энэ спортын сайд нарын чуулга уулзалтад оролцоод ирлээ. Энэ ковидоос шалтгаалаад 6 жил болж байгаад ингээд оролцож байна. Азербайжан улсын Баку хотод зохион байгуулагдсан. Тэгээд тэр Азербайжан улсын хөгжил дэвшил энэ байгалийн баялгаа төрийнхөө мэдэлд аваад төрд ажиллаж байгаа улсууд нь асар их өндөр ёс зүйтэй, сахилга хариуцлагатай энэ улс орон ард түмнийхээ төлөө тэр байгалийн баялгийг яаж зарцуулж болдог юм. Үлгэр жишээ болоод ингээд ажилласан тэр хот төлөвлөлт, хүмүүсийн амьдралын байдал, үзэл ухамсар хаана ч орсон тэнд архи уугаад сууж байгаа улсууд харагдахгүй байх юм байна шүү дээ. Архи ниво эргүүлээд байж байгаа улсууд. Гудамжинд нь зам талбайд нь одоо ил задгай шүлс, нусаа хаясан, хог тамхины иш хаясан тийм юм огт харагдахгүй байна шүү дээ.

Тэгээд энэ талаас ер нь та нар үзсэн ийм зүйл байна уу? Японы нэг судлаач хүн хэлсэн байдаг шүү дээ. Монголчууд та нар хөгжихөд их хэцүү. Яагаад гэвэл та нарт хөгжлийн ёс суртахуун байхгүй гэж хэлсэн гээд. Гаднын ийм судлаач хүмүүс бид нарын хөгжихгүй байгаа явахгүй байгаа шалтгааныг чинь олж харж хэлээд байдаг. Гэтэл та бүхэн маань энийг ер нь юу гэж үздэг юм? Харьцуулсан ийм үзсэн, судалгаа хийсэн, үнэлэлт дүгнэлт өгсөн ийм зүйлүүд байна уу гэж, нэг.

Нөгөө талынх нь юм бол энэ соён гэгээрүүлэх, ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ ажил бол үнэхээр их чухал юм. Энэ ажлыг болдог бол боловсролын системээр дамжуулаад сургуулийн өмнөх боловсролоос нь тэр хүн өсөх орчин болсон гэр бүлээс нь, эх эцэг

асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч, суралцагч ийм 3 хэлхээ холбоонд нь авч үзэж энэ асуудлыг нэлээн өргөн хүрээнд авч үзэхгүй бол төрийн үйлчилгээ үзүүлж байгаа хууль хүчний байгууллагууд байна. Өчнөөн олон асуудалтай. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа энэ эрүүл мэндийн салбарын хүмүүс. Үйлчилгээтэй холбоотой маш их гомдол санал байна.

Дээрээс нь боловсролын салбар байна гээд. Ерөөсөө салбар болгонд энэ харьцаа хандлага ёс зүйн асуудал үнэхээр тулгамдсан ийм асуудал болоод байна. Тэгэхээр зэрэг бид нарын зорилго бол нөгөө гарсан үр дагавартай нь гарсан зөрчлийг нь олж тогтоогоод тэнд хариуцлага шийтгэл ноогдуулахаасаа илүү урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлийн ямар томоохон хөтөлбөр байх вэ?

Үүнийг урьдчилж харсан ямар зохицуулалт.

**Б.Баттөмөр:** Хэн хариулах вэ? 3 номер Сүрэнчимэг хариулъя.

**Д.Сүрэнчимэг:** Эрхэм Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Бат-Эрдэнэ гишүүний асуусан эхний асуултад хариулъя.

Ёс зүй ёс суртахуунтай холбоотой бусад улс орнуудын нөхцөл байдлыг судалсан судалгааны талаасаа Удирдлагын академи, Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн дараагаар Засгийн газрын болоод Төрийн албаны зөвлөлийн захиалгаар судалгаат ажил судалгааны ажлуудыг хийдэг. Нийтдээ одоогоор 37 судалгааны ажил хийгээд байгаа. Энэ судалгааны ажлуудын хүрээнд ёс зүй, ёс суртахуунтай холбоотой, төрийн албан хаагчийн үнэт зүйлтэй холбоотой судалгааны ажлууд хийгдсэн ажлууд бол бий. Тэгээд энэ ажлуудыг хуулийн төслийг

боловсруулахад ашиглаж ажилласан. Хамгийн сүүлд хуулийн төслийн ажил явж байгаатай зэрэгцүүлээд хийж байгаа нэг томоохон урт хугацааны судалгааны ажил бол Монгол төрийн уламжлал, үнэт зүйлийг судлах ийм ажил 2021 оноос хойш хийгдэж байна.

Тэгэхээр үнэт зүйлийн хувьд бид нар яг өнөөдөр эд агуурстай, яг мөн чанар үнэт зүйлээ ойлгох зүйлээ хольж ойлгож байгаа ийм зүйлсүүд байгаа учраас энийг яг сууриар нь бид нар яаж харах ёстой юм гэдгийг эх бичгүүд уламжлалт бусад материалуудыг судлаад ер нь бид үнэт зүйл гэж нэрлэх биш харин яг тухайн зүйлийнхээ төлөө амиа ч зориулахад бэлэн байх энэ зүйлийг бол эрхэм нандин буюу эрхэмж гэж нэрлэх нь зүйтэй юм гэсэн ийм судалгааны саналыг гаргаад явж байгаа. Яг үүнтэй уялдуулаад алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг төрийн албан хаагчдад танилцуулах ийм сургалтын ажлыг 2023 онд бид нар нийтдээ 42 мянган төрийн албан хаагчдадаа хүргээд байна. Энэ сургалтын хүрээнд бид нар төрийн албан хаагчдын үнэт зүйлийн одоогийн бидний нэрлэж байгаагаар эрэмбэ ямар байдалтай байна вэ гэдэг дээр судалж ажилласан. Яг энэ эрэмбийн талаасаа хувь хүний хувьд үнэтэй гэж харж байгаа зүйл. Төрийн албан хаагчийн хувьд, улс орны хувьд үнэтэй гэж харж байгаа зүйлийн судалгааны нэгтгэл юмыг гаргасан. Энэ талаар тусгайлан ярилцаж ойлголцох ийм хэрэгцээ бол нэлээд их байна гэж ийм зүйл бол харагдаж байгаа.

Засгийн газрын 340 дүгээр тогтоолын хүрээнд сая яг Бат-Эрдэнэ гишүүний асуусан Эрүүл мэнд, боловсрол, соёл спортын салбарын ямар ажлууд дээр яг төр хувийн хэвшилтэй хамтрах вэ? Тэр дундаа яг асуудал дагуулаад байгаа харилцааны энэ асуудал үүний цаана байгаа ёс зүй, ёс суртахууны асуудал дээр ямар байдлаар ажиллах вэ гэдэг дээр жишиг загвар гаргаж ир гэдэг ийм даалгаврын дагуу тодорхой ажлууд бас хийгдэж байна.

Яг одоогоор бид нарт ийм үр дүнд хүрчихлээ гэдгийг нэгтгэж хэлэх цаг хугацааны боломж бүрдээгүй байгаа.

Тэгээд асуултын даширамд яг спортын чиглэлээр тэр дундаа яг 340-ийн хүрээнд бид нарт хамтарч ажиллах өргөн нөхцөл боломжууд бас хэрэгцээ шаардлагууд байна гэдгийг эрхэм гишүүнд бас хүсэлт болгон илэрхийлье.

Энд үнэт зүйл буюу эрхэмжийн талаарх ойлголтуудаа бид нар нэлээд ижил түвшинд аваачиж байж яг энэ хуулийн хэрэгжилт өнөөдрийн журмуудыг ойлгох ойлголтууд маань хэрэглэхэд илүү хялбар болно гэсэн ийм зүйлийг хариулья.

Баярлалаа.

**Б.Баттөмөр:** Болсон уу? Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулья Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм батлах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь заалт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсгийг үндэслэн Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооноос тогтоох нь:

Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг, үүрэг бүхий Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрмийг хавсралтаар баталсугай. Энэ тогтоолыг 2023 оны тэдэн сарын тэдний өдрөөс дагаж мөрдөнө өө.

Байнгын хорооны дарга гэсэн ийм тогтоолын төсөл байгаа. Энийг тараачихсан байгаа.

Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны ажиллах дүрмийг батлах

тухай Улсын Их Хурлын Ёс зүй сахилгын хариуцлагын байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 66.7 хувийн саналаар санал дэмжигдэж байна.

### 13.55 цагт

Дараагийн асуудалд орёе.

*Байнгын хорооны тогтоол. Ёс зүйн хорооны орон тооны бус Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.*

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ байгаа.

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Энхболд гишүүнээр тасалъя.

Энхболд гишүүнд микрофон өгье.

**Н.Энхболд:** Энэ дээр нэг ийм зүйлүүд сая уншиж байхад харагдаж байна. Одоо жишээ нь Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлага гэж байна. Тэрний 2.1.8 дээр хорооны гишүүдтэй нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн эс үгүй хамаарал бүхий этгээд биш байна гэсэн ийм заалт орсон байна. Нэг нутгийн гэснийг Төрийн албаны тухай хуульд зааснаар ойлгоно гээд. Ерөнхий санааг нь ойлгож байна. Зөв

болов уу гэж зөв байх гэж бодож байна. Гэхдээ энэ дарааллын хувьд жишээ нь хорооны гишүүд 5 гишүүн автоматаар бий болчхож байгаа.

Нэгдүгээрт энэ 2.1.8-ын хорооны гэдэг дээр аль аль хороог хэлж байна. Байнгын хорооны гишүүд үү, эс үгүй бол төрийн албаны 5 гишүүнийг хэлж байна уу? Тэрийгээ тодруулмаар байна. Төрийн албаны албаны 5 гишүүн автоматаар орчихсон явна. Тийм ээ, тэгэхдээ тэр 5-ыг хороо гэж үзэх үү үгүй юү гэдэг асуудал байгаа юм.

Тэр 5-ыг хороо гэж үзвэл хамаагүй энд хорооны гэдэг үгээр явж болж байна эс үгүй бол Байнгын хорооны гишүүд байх юм уу? Энүүнийг нэг тодруулмаар байна I дүгээрт.

Хоёрдугаарт энэ улсууд урьдчилаад тодорчихно. Тэгээд дараа нь нэр дэвшүүлэх хүмүүсийн эрх нь хаагдчихаж байгаа байхгүй юу. Яагаад? Жишээ нь нэг анги төгссөн хүн нэрээ дэвшүүлж болохгүй байдаг юм гэдэг асуудал гарна. Тэгэхээр энийг энд байх уу, хойно жишээ нь нууцаар санал хураах эс үгүй бол нэр дэвшигчийг жагсаалтад оруулахдаа оруулаад санал хураахдаа хорооны гишүүд нь яг тийм хамааралтай хүмүүс байвал би тэгвэл энэ санал хураалтад орохгүй ээ. Яагаад гэвэл энэ эс үгүй бол манай Төв аймгийн хүн байна гэдэг юм уу, эс үгүй бол энэ надтай 10 төгссөн, дээд сургууль төгссөн хүн байна гээд өөрийгөө татаж аваад санал хураалтад оруулахгүй оролцохгүй байх тухай нэг ийм боломж байгаа юм.

Тэгэхээр энийг хаана оруулах вэ гэдгээ хэдүүлээ нэг бодмоор байна. Зүгээр шууд автоматаар хасчихъя гэж гишүүдийн олонх үзвэл хамаа алга. Одоо тэр 5 хүн байж байгаа шүү дээ. Тэр хороо гэдгийг юу гэж ойлгох вэ гэдгээ эхлээд хэдүүлээ тодруулчихмаар байгаа юм. Нөгөө 5 хүн үү, эс үгүй бол Байнгын хороо юу. Тэр хүнийг нэр дэвшүүлэхдээ ямар шаардлага тавих юм гэдэг нь урьд нь

байж байгаа тэр хүмүүсээс хамааралгүйгээр сонгогдчихсон тэр хүмүүсээс болоод тэр цаад хүмүүсийн эрх нь хаагдчихаж байгаа байхгүй юу. Энэ зөв үү буруу юу гэдгээ нэг ярьж авмаар байна.

Тэгээд энүүнийг бид нар жишээ нь ажлын хэсгийн гишүүнд хориглох зүйлүүд дээрээ байх байна уу? Тэрний 6.2.1 дээр бас байгаа юм л даа. Нэр дэвшигчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, ажиллагч, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү байх гээд ажлын хэсгийн гишүүнд хориглох зүйлүүд дээр бас байж байгаа. Эд нарыг яаж хаана оруулах вэ гэдэг дээр. Одоо жишээ нь ингээд дараа нь бид нар ажлын хэсгийн гишүүд гээд байгуулах гэж байна л даа 9 хүний. Эд нар чинь эхлээд автоматаар сонгогдчихно. Тэгээд нөгөө цаад улсуудын юманд түрүүлж сонгогдсон бид нарын байдлаас болоод тэр хүмүүсийн эрх нь хаагдах уу үгүй юу гэдгийг бид нар нэг дотроо ярьж явж байгаад энэ 6.2, 2.1.8 гэсэн зүйлүүдийг нэг бодолцмоор байна. Би ер нь болохгүй гэж байгаа юм биш. Тэгэхдээ яаж оруулбал их зөв байх вэ гэдгээ бодмоор байна. Эс үгүй бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тэр 8 дугаар бүлгийн 8.2 дээрээ оруулах уу? Энэ юмнуудаа тал талаас нь нэг ярьчихмаар байна.

Нэг бүлэг асуудал бол.

Хоёр дахь нь энэ нэр дэвшигчийг Байнгын хороонд санал болгохдоо 11.2 дээр байгаа ажлын хэсгийн бүр саналаа илэрхийлж зөвлөлдөнө гэж байгаа юм. Энэ хүнийг дэвшүүлэх үү, үгүй юу гэдгээ ярилцахын дараа. Тэгээд дараа нь 11.4.2 дээрээ саналаа нууцаар явуулна гэж байгаа юм. Тэгэхээр зөвлөлдөнө гэдэг чинь хүн болгон тодорхой хэмжээгээр өөрийнхөө байр суурийг илэрхийлчихнэ гэсэн үг шүү дээ. Болж байна, болохгүй байна уу гээд. Тэгэхээр дараа нь нууцаар гэдэг юм нь бас жоохон утгагүй болчихоод байгаа юм. Нэгэнт зөвлөлдөх үеэрээ болж байна, болохгүй гэж хэлчхээд. Дараа нь санал хураах үедээ нууцаар байна гэдэг

логик уялдаа нь ямар байна вэ гэж. Тэгээд би бол жишээ нь ажлын хэсгийн ярилцлагын дүнгээ үндэслээд нэр дэвшүүлнэ гээд л орхичихвол хүн бүр саналаа илэрхийлж зөвлөлдөнө гэдэг юмаа хасчихвал дараа нь тэртээ тэргүй.

**Б.Баттөмөр:** Энхболд гишүүнд дахиад нэг минут өгчихье.

**Н.Энхболд:** Нууцаар санал хураалгах, явуулах нь зөв. Тэгээд тэрнээсээ өмнө хүн болгон саналаа хэлж зөвлөлдөх нь зөв үү, буруу юу? Тэр заалтыг хасчхаад л. Гишүүн болгонд материалыг нь өгчихнө. Танилцчихаад зөвлөлдөхгүйгээр нууцаар саналаа хураахад л тэртээ тэргүй нууцаар гэдэг үгийнх нь утга тэнд л гарч ирэх ёстой гэж би бодоод байна л даа. Тэгээд энэ 2 асуудал дээр хэдүүлээ нэг саналаа солилцвол ямар вэ гэж.

11.9 дээр байна. Одоо жишээ нь 4 хүн бид нар дэвшүүлэх ёстой тийм ээ. Гэтэл нууц санал хураалтаар 3 хүн гараад ирвэл дахиад нэг хүний талаар зар тавих юм уу, эс үгүй бол нөгөө түрүүчийн улсууд дотроосоо хамгийн 5 дахь санал авсан хүнийгээ дэвшүүлэх юм уу гэдэг юмаа бас нэг ярьчихмаар юм шиг.

**Б.Баттөмөр:** Хэн хариулах вэ? Бат-Эрдэнэ Нэг номерын микрофон.

**Ч.Бат-Эрдэнэ:** Төрийн албаны зөвлөлийн маргаан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ Энхболд гишүүний асуултад хариулъя. Гишүүний асуусан журмын төслийн 2.1.8-д заасан хорооны гишүүдтэй нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн эсвэл хамаарал бүхий этгээд биш байх гэдэг энэ зохицуулалт байгаа юм. Энэ зохицуулалтын хүрээнд яг энэ дүрмийн 2 дугаар зүйл маань өөрөө Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлага гэдэг ийм зохицуулалтын хүрээнд доор нь нарийвчлагдаж ингэж орж ирж байгаа. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд яг мөн адил энэ шаардлагыг тавьдаг. Мөн



Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн дүрэмд энэ зохицуулалт орчихсон байдаг.

Тэгэхээр энэ зохицуулалтыг гишүүний хэлдгээр 8.2 дахь хэсэг буюу доор дурдсан тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзана гэдэг энэ нэр дэвшигчээр бүртгэх энэ үйл ажиллагааны процесст хойшоогоо оруулаад өгөхөд боломжтой гэж харж байна. Зүгээр энэ заалтыг бүүр ор тас ингээд хасна гэх юм бол нөгөө орон тооны 5 гишүүн, орон тооны бус 4 гишүүнд тавигдах энэ шаардлага нь бол дундаа бас зөрөө гарах ийм өөр шаардлага тавих ийм асуудал үүсэх ийм эрсдэл байгаа гэж ойлгож байгаа.

Гишүүний дараагийн асуулт буюу энэ дүрмийн төслийн 11.2 дахь заалт байж байгаа. Энэ зөвлөлдөнө гээд ингээд оруулчихсан байж байгаа. Бид бүхэн энэ төслөө боловсруулахдаа бас ХЭҮК-ын гишүүн сонгон шалгаруулах журам мөн Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг сонгон шалгаруулах журмуудын хүрээнд бас үзэж танилцаж ингэж авч үзсэн байгаа юм. Тэгээд яг ингээд бас уншигдахаар саяын дурдсан байгууллагууд дээр бол бас олон тооны гишүүдийн сонгон шалгаруулалтын асуудал нээлттэй сонсголын асуудлууд явдаг учраас энэ зохицуулалт үлдчихэж байсан. Тэгэхээр гишүүний хэлдгээр зөвлөлдөнө гэдэг энэ ойлголтыг хасаад санал хураалтыг нууцаараа явуулна гэдэг энэ зохицуулалтаа үлдээгээд санал хураалтыг нууцаар явуулах өөрөө зохицуулалт маань аливаа ашиг сонирхлын зөрчлөөс бас ажлын хэсгийн гишүүдийг урьдчилан сэргийлж хамгаалж байгаа ийм агуулгагүй зохицуулалт учраас зөвлөлдөнө гэдэг энэ агуулгыг хасах ийм бүрэн боломжтой гэж ойлгож байна.

Хамгийн сүүлийн асуулт буюу энэ 11.9 дэх заалт байж байгаа. Энэ дээр гол ойлголт нь анхаарах асуудал нь энэ зохицуулалт нь юу вэ гэхээр олонхын санал аваагүй гэдэг ийм агуулга явж байгаа.

Тэгэхээр үнэхээр энэ Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч маань энэ сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авч чадахгүй байх юм бол энэ дээр бол тэр материалаа нэр дэвшигч нарыг олонхын саналыг нь аваагүй босго даваагүй гэдэг үндэслэлээр дахиж авсан онооны дарааллаар нь нэр дэвшүүлэх боломжгүй гэж үзээд ахиад нээлттэй зараа тавиад ингээд энэ журмынхаа дагуу үйл ажиллагаагаа зохицуулах нь зүйтэй гэж бас ажлын хэсэг дээрээ ярьсан. Энэ нөгөө ёс зүйн өндөр мэдрэмжтэй, манлайлалтай энэ хүнийг ажлын хэсгийн гишүүдийн олонх дэмжээгүй бол нэр дэвшигчийг бол цаашид энэ орон тооны бус гишүүнээр томилох боломжгүй юм гэдэг ийм саналуудыг ажлын хэсгийн гишүүдээс гаргаж байсан байгаа юм. Хариулж дууслаа.

**Б.Баттөмөр:** Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Тэгээд яг энэнтэй уялдуулаад бас нэг зүйлийг тодруулъя. Одоо жишээ нь энэ нэр дэвшүүлэх комиссоос, ажлын хэсгээс Байнгын хороонд хэдэн хүн олонхын саналыг авсан бүх хүмүүсийг оруулаад тэрэн дотроос Байнгын хороо 4 хүнээ сонгох юм уу, эс үгүй бол хамгийн санал авсан 4 хүнийг оруулах юм уу гэдэг асуулт бас эндээс гарч ирж байгаа юм.

Дээр нь 9 хүн саналаа ирүүлчихсэн гэж бодъё нэр дэвшигч ээ гээд. Тийм ээ ингээд 1, 1-ээр нь хураана шүү дээ бид нар чинь. 11 хүн ирсэн гэж бодъё л доо. Тэгээд энэ нөгөө сонгож нэр дэвшүүлэх ажлын хэсэг маань хүн болгоноор хураагаад байсан чинь 3 нь л олонхын санал аваад, 8 нь олонхын санал авсангүй. Тэгэхээр яах вэ гурвыгаа Байнгын хороондоо нэр дэвшүүлнэ. Нэг хүнээ дахиад.

**Б.Баттөмөр:** Хэн хариулах вэ? Бат-Эрдэнэ нэг номерын микрофон өгье.

**Ч.Бат-Эрдэнэ:** Энхболд гишүүний асуултад хариулъя.

Гишүүний гаргаж байгаа саналын дагуу энэ тодотгох, илүү ойлгомжтой болох үүднээс тодотгосон ийм найруулгыг нь сайжруулах нь зүйтэй гэж ойлгож байна. Тэгээд энэ дээр хамгийн өндөр оноо авсан 11 хүний хувьд хамгийн өндөр оноо авсан гэхдээ нөгөө ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан энэ хүмүүсээ оруулж ирье ээ гэж. Тэгэхээр мэдээж 4-өөс олон хүн олонхын санал аваад ингээд ороод ирэх юм бол нөгөө онооны дарааллаар нь эхний 4 хүнийгээ сонгож аваад явъя гэдэг ийм зарчмаар боловсруулагдсан байгаа. Харин гишүүний саяын хэлдэг 11 хүн орж ирээд 8 нь олонхын санал аваагүй, 3 хүн нь олонхын санал авах юм бол энэ 3 хүнээ цааш нь нэр дэвшүүлэх процессоороо явуулъя.

Нэг сул орон тоон дээрээ бол дахиж шинээр зарлаад.

**Б.Баттөмөр:** Бат-Эрдэнэд дахиад нэг минут өгье. Нэг номерын микрофон.

**Ч.Бат-Эрдэнэ:** Энэ 8 хүн нь олонхын санал аваагүй бол ингээд энэ 8 хүнийг дахин энэ сонгон шалгаруулалтад оролцуулахгүй ахиад нээлттэй зараа тавиад ингээд шинээр хүмүүсийг эрэлхийлэх ийм зохицуулалтаар боловсруулагдсан байгаа. Сая ажлын хэсэг дээр бол ярьж байгаа нь энэ одоо зөвхөн нэр дэвшээд хүн материалаа өгснөөс гадна шилж сонгож олох тэр ёс зүйн өндөр манлайлалтай хүнийг шилж сонгож олох энэ зохицуулалт байх ёстой юм биш үү гэдэг энэ санаа хүртэл ажлын хэсгийн гишүүдээс бас гарч байгаа.

**Б.Баттөмөр:** Энхболд гишүүнд дахиад нэг минут өгье.

**Н.Энхболд:** Тэгвэл 11 хүнээс маань зургаа нь олонхын санал авчихлаа. Тийм ээ эрэмбэлчихлээ. Эхний дөрвөө оруулаа. Байнгын хороон дээр нэг нь уначихлаа. Тэгвэл яах вэ? Үлдсэн нөгөө 6 дотроосоо 5

дахь хүнээ оруулах уу дахих уу? Энэ юмнуудаа бид нар бас тодруулмаар байна. Тэгэхгүй бол тэр үед тодорхойгүй үлдчихвэл тэгээд л нэг ойлгомжгүй юм болно шүү дээ тийм ээ. Нэгэнт олонхын санал авчихсан. Тэнцэж байна гээд үзчихсэн. Нөгөө түрүүчийн 4 дэх хүнээсээ 5 дахь нөхөр нь 2 оноогоор юм уу, оноо өгчихөж байх юм шиг байна л даа дутчихлаа гэж бодъё. Тэгсэн 4 дэх нөхөр маань Байнгын хороон дээр нэг асуудал гарч ирээд олонхын дэмжлэг авалгүй уначхаад 3 хүн нь орон тооны бус гишүүнээр сонгогдчихоод нэг орон тоо үлдчихвэл дахиад цоо шинээр сонгон шалгаруулалт явуулах уу, эс үгүй бол нөгөө 5-д орсон, тэгэхдээ олонхын санал авчихсан болно гээд үзчихсэн.

**Б.Баттөмөр:** Хэн хариулах юм. Бат-Эрдэнэ нэг номерын микрофон.

**Ч.Бат-Эрдэнэ:** Гишүүний бас саяын хэлсэн саналын дагуу бас тодотгоод нарийвчилсан зохицуулалтыг оруулъя. Үнэхээр яг 5 хүн олонхын санал аваад ингээд Байнгын хороон дээр бол нэг хүн нь дэмжигдэхгүйгээр ингээд явсан тохиолдолд дараагийн тэр онооны дарааллаар гэхдээ олонхын санал авсан энэ хүнийг нэр дэвшүүлэх ийм боломжоор нь хангах үүднээс энэ дээрээ нарийвчлаад бас тодотгоод зохицуулалт оруулъя гэсэн гишүүний саналын дагуу зохицуулалт оруулъя аа.

**Б.Баттөмөр:** Энхболд гишүүн дахиад нэг минут өгье.

**Н.Энхболд:** 11.5 дээр бол бид нар ерөнхийдөө сул орон тоогоор гээд ингээд яваад байна л даа. Одоо бол бид нар анх удаа энийгээ хийнэ шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэний 11.5-ын доор тайлбар хийгээд анхны удаа энэ сонгуулийг явуулахад бол энэ ингэж юу яана. Энэний дараа орон гарсан тохиолдолд ийм зарчим баримтална гэсэн нэг тийм тайлбараа бас оруулчихаад явчихсан нь зөв болов уу гэж бодож байна. Тэгэхгүй бол одоо ингээд шууд эхний сонголтыг хийнэ гэхээр

сул орон тоогоор гээд биччихсэн хүн чинь яах вэ бид нар ойлгоно л доо. Сул 4 оронтой сул байж байгаа энэ дээрээ ингээд явчихна гээд. Тэгэхээр хамгийн анхныхныхаа талаар нэг тайлбар 11.5-ынхаа доор хийгээд. Тэрнээс хойш бол ямар нэгэн шалтгаанаар сул орон тоо гарвал тэрийг ингэж явуулна гэдэг тайлбар байгаа. Эс үгүй бол сул орон тоо гарвал энэ журмынхаа тэр тэр заалтуудын дагуу тэр сул орон тоог нөхөж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна гэсэн.

**Б.Баттөмөр:** Сая Энхболд гишүүний хэлсэн саналтай санал нэг байна уу? Санал нэг байгаа юм.

**Н.Энхболд:** Би Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Ёс зүйн байнгын хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журам Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт 24 дүгээр зүйлийн 24.4.1 24.4.2 дахь заалт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт нь Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг 1 дүгээр, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүний сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудсыг 2 дугаар хавсралтаар.

Сонгон шалгаруулах комиссын гишүүний баталгаа 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Энэ тогтоолыг 2023 оны ... дүгээр сарын ...нээс эхэлж дагаж мөрдөнө өө. Байнгын хорооны дарга гэсэн ийм тогтоолын төсөл байгаа.

Энийг цахимаар болон бичгээр тараачихсан байгаа.

Сая Их Хурлын гишүүдээс зарим гишүүдээс тодорхой саналуудыг хэллээ. Ингээд энэ саналуудыг тусгаад Ёс зүйн хорооны орон тооны бус гэж гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7%-ийн саналаар дэмжигдэж байна.

Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Намайг буруу юм хэлээд байвал та бүхэн минь уучлаарай. Тэр 6.2.1 дүгээр заалт байна шүү дээ. Энэ чинь ажлын хэсгийн гишүүнд хориглож байгаа болохоос биш нэр дэвшиж байгаа хүнд хориглож байгаа юм биш байхгүй юу. Тэгээд ажлын хэсгийн гишүүд чинь одоо бид нарыг ингээд томилчихно шүү дээ. Тэгэхээр дараа нь хэн нэр дэвшихийг мэдээгүй байж байж бид нарт юм хориглох нь утгагүй байхгүй юу. Тэгэхээр энэ болохгүй шүү ийм байж болохгүй шүү гэдэг заалтаа хаана оруулах вэ гэдгээ бид нар бас бодохгүй бол одоо бид нар энэний дараа ажлын хэсгээ байгуулчихна тийм ээ. Тэгээд нэрсүүд гарчихна шүү дээ. Тэгсэн дараа нь нэг нөхөр дэвшээд ирсэн чинь миний нэг хамаарал бүхий этгээд дэвшээд ирсэн чинь надад хориглохож байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол одоо тэр хүний ах юм уу хамаатан хамаарал бүхий этгээд байхыг надад хориглоод байхгүй. Аль хэдийн сонгогдчихсон батлагдчихсан надад тийм ээ тэгээд орж ирж байгаа хүнд нь ийм юм хориглоно гэдэг утгаар зөв газар нь байрлуулахгүй бол уяе томилогдчихсон надад хориглоод энэ чинь яах вэ утгагүй байхгүй юу. Төрсөн аав, ээж байхыг нь хориглоно гэж байгаатай адилхан юм дуулдаад байгаа байхгүй юу. Хүүхэд нь ямар нэгэн юманд нэр дэвшээд ингээд явал тэгвэл чи аав нь биш шүү чамд аав байхыг нь хориглож байна гэсэнтэй адилхан сонсогдоод байгаа юм.



Тэгэхээр яг энэ 6.2.1 гэдэг заалтаа бас хаана яаж зөв оруулбал зөв сонсогдох нь вэ, зөв ойлгогдох нь вэ гэдгээ бас нэг бодоорой гэж сая бодогдчихлоо.

**Б.Баттөмөр:** Тэр сая Энхболд гишүүний хэлсэн саналыг бас та нар үзээрэй. Бас чухал зөв санаа ирж байна шүү.

14.17 цагт

Дараагийн асуудалд орёё.

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийг урьдчилаад тараачихсан байгаа. Цахимаар тараасан, бичгээр тараасан байгаа цаасаар тараасан байгаа.

Ёс зүйн байнгын хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол сонгон шалгаруулалт батлах ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь заалт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11.11.4, 11.5 дахь хэсгийг тус үндэслэн Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт нь Төрийн албан хаагчийн ёс зүйн хуульд Монгол Улсын Их Хурлын Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны сая батлагдах тогтоолоор баталсан.

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 5-д заасныг үндэслэн Ёс зүйн хорооны орон тооны бус 4 гишүүнийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч нь Нямаагийн Энхболд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн, Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн, Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн, Энэбиш Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх, Сувдмаа ЗГХЭГ-ын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ч.Батэрдэнэ Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга, Т.Энхболд АТГ-ын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Адыаахишиг Хүний эрхийн Комиссын Тамгын газрын дарга, Жолбарс Монголын Хуульчдын Холбооны Тамгын газрын дарга.

Хоёрдугаарт нь ажлын хэсэгт мэргэжил арга зүйн зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Ажлын хэсгийн гишүүн Энэбишийг томилсугай.

Улсын Их Хурлын Ёс зүй сахилга, хариуцлагын байнгын хорооны дарга Баттөмөр гэсэн ийм тогтоолын төсөл байна. Ингээд Ёс зүй, сахилга хариуцлагын орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хуралдаанд оролцсон гишүүдийн 66.7 хувийн саналаар дэмжигдэж байна.

Өнөөдрийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос зохион

байгуулж байгаа тогтоолын төсөл болон сонгон шалгаруулалттай холбоотой асуудлуудыг хэлэлцэж дууслаа.

Та бүгдэд баярлалаа.

14.20 цагт

Дараагийн асуудал.

2022 оны төсвийн гүйцэтгэлийг ярина. Эдийн засгийн байнгын хороон дээр үргэлжилж байна. ингээд ороод ирнэ. Сангийн сайд, Улсын аудитын газрын дарга.

Алын хэсгийн гишүүдэд дахиж талархсанаа илэрхийлье ээ. Та нар бас сайн ажиллацаалаа. Зөндөө их бичиг цаас нухлаа. Одоо ингээд сонгон шалгаруулалтыг яг журмынх нь дагуу зарлаад тэгээд зохион байгуулаад 4 гишүүнээ томилоод Төрийн албаны зөвлөлийн 5 гишүүн байгаа. Ингээд ажиллана салбар зөвлөлүүдээ, дэд хороодуудаа байгуулна.

Тэгээд энэ хуулийнхаа хэрэгжилтийг хангах чиглэлээр маш их ажлууд зохион байгуулагдана. Та бүхэнд амжилт хүсье ээ.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье ээ.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн энэ талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Жавхлан сайдыг урьж байна байна.

**Б.Жавхлан:** Эрхэм байнгын хороон дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тэнцвэржүүлсэн орлогын дүн 2022 онд 17.1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18.1 их наяд төгрөг, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтайгаар төлөвлөгдсөн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах АТГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын нийт 2 байгууллагын төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 33.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч урсгал зардалд 32.6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 0.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 93.4 хувь буюу 31 тэрбум төгрөгийг АТГ-ын дарга 6.6 хувь буюу 2.24 тэрбум төгрөгийг үйлдвэрийн албаны зөвлөлийн даргын зарлага эзэлж байна. Улсын төсвөөс 33.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох

тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж Төсвийн тухай хуулийн Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баттөмөр:** Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат танилцуулна.

Занданбат даргыг урьж байна.

2 номерын микрофоныг өгье.

**Д.Занданбат:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус байнгын хороонд харьяалагдах Төрийн албаны зөвлөл, АТГ-ын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2000000407.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2000000252.3 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Төсвийн нийт зардал 2000000202.6 сая төгрөг буюу 91.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Аудитаар санхүүгийн тайлангийн 18,6 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах 3 зөвлөмж бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчилд 3 зөвлөмж тус тус өгсөн.

Нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 4 алдааг аудитын явцад залруулсан. Өмнөх оны аудитын илрүүлэлттэй харьцуулахад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдааны дүн 1000000265.6 сая төгрөг болсон байна. АТГ-ын даргын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх нэг хөтөлбөр, 10 зорилт арга хэмжээг санхүүжүүлэхээр 32000000902.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 32000000330.5 сая төгрөг хөрөнгийн зардалд 572.1 сая төгрөгийн төсөв батлагдаж 32000000902.5 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Төсвийн нийт зардал 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

АТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд өөрчлөлтгүй дүгнэлтийг өгсөн. Тус байгууллагын эзэмшлийн хэвлэлийн цехийг тоног төхөөрөмжийн хамт хуулийн этгээдэд түрээсэлсэн боловч түрээсийн гэрээнд 5 нэр төрлийн тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөрийн тодорхой тусгаагүй зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх нэг зөвлөмжийг хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалтаар нийт 1 тэрбум 43 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Ажлын бодит гүйцэтгэл 100 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 54.8 хувьтай байна. Өмнөх оны аудитын илрүүлэлттэй харьцуулахад алдаа зөрчил 90.5 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын дүн дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлыг тоймлон танилцуулъя.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2024 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшин тодорхойгүйгээс улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Б.Баттөмөр:** Занданбат даргад баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн дарга, Баасанням АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Дуламсүрэн АТГ-ын Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын албаны дарга, Ганбат Сангийн яамны ТНБД, Тавинжил Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Төслийн хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

орлуулалтын газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Мөнгөнцэцэг Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч, Эрдэнэбаатар Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Занданбат Ерөнхий аудитор, Наранчимэг Ерөнхий аудиторовын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Самбууням Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэлийн нийцлийн аудитын газрын захирал гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдөр хуралд оролцож байна.

Ингээд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан, аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Энхболд гишүүн асууна. Дараа нь би асууна.

Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Аудитын газрын аудитад хэн аудит хийдэг юм бэ? Өөрөө өөрсдөдөө хийх үү дүгнэлт юу гэж гардаг юм. Нэг тийм асуудал байна. АТГ дээр хэмнэлтүүд гарсан байна. Энэ нөгөө хэмнэлтийн хуультай холбогдоод гарав уу, эс үгүй бол бусад шалтгаанаар 2 тэрбум орчим төгрөгийн хэмнэлт гарсан байна уу? Ийм 2 зүйл лавлъя.

**Б.Баттөмөр:** Манай байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарагддаг Төрийн албаны зөвлөлийн төсвийн багцын гүйцэтгэл болон санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас өөрчлөлтгүй гэсэн дүгнэлт гаргасан байгаа. АТГ-ын мөн санхүүгийн нэгдсэн тайланд заасан хугацаанд өөрчлөлтгүй гэсэн дүгнэлтүүд тус тус гарсан байна. Энхболд гишүүний асуултад хэн хариулах вэ? Занданбат дарга. 2 номерын микрофон өгье.



**Д.Занданбат:** Энхболд гишүүний асуултад хариулъя.

Аудитын төсвийн гүйцэтгэлд санхүүжилтийн гүйцэтгэлд Төрийн аудитын тухай хуулиараа Улсын Их Хурлын даргаас итгэмжлэгдсэн хараат бус аудитын компани тусгайлан итгэмжлэл авч тэнд аудит хийдэг. Түүний дүн бол бас энэ Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдээд ордог. Тэгээд тэр дүнгүүд бол тайланд байгаа.

**Б.Баттөмөр:** АТГ Баасанням хариулах уу? 4 номерын микрофон дээр суучих.

**З.Баасанням:** АТГ-ын Тамгын хэлтсийн дарга Баасанням.

Энхболд гишүүний асуултад хариулъя.

Өнгөрсөн 2022 оны хэмнэлт үндсэндээ цалин хөлс ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, норматив, зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зардал бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас гэдэг нийт зардлуудаас үндсэндээ хэмнэлтийн, төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд энэ зардлууд хэмнэгдэж гарсан байгаа.

**Б.Баттөмөр:** Надад асуултууд байна. Энэ 2022 оноос Монгол Улсын Засгийн газраас хэмнэлтийн бодлого явуулсан. Энэ хүрээнд бас нэлээн олон ажлууд хийгдсэн гэж ойлгож байгаа. Яг энэ хэмнэлтийн тэр хуультай холбогдуулаад ямар үр дүн 2022 онд гарсан гэсэн нэг ийм асуулт байна? Энийг хэн хариулах юм?

Хоёрдугаарт Энэ Монгол Улсын хөгжилд энэ төрийн өмчтэй

компаниудын гүйцэтгэх үүрэг онцгой ач холбогдолтой.

Гүйцэтгэж байгаа Эрдэнэс Тавантолгой компани Монгол Улсын эдийн засагт өөрөөр хэлбэл төсвийн орлогын бас нэлээн хувийг оруулж байгаа Эрдэнэт үйлдвэр байна гэх мэтээр. Гэтэл энэ төрийн өмчтэй компаниудын энэ менежмент энэ тэртэй холбоотой бас янз бүрийн асуудлууд их гарч байна л даа.

Жишээлбэл энэ зарим ААН-үүд Ирээдүйн өв санд өөрөөр хэлбэл 85 орчим тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн гэсэн ийм аудитын дүгнэлт гарсан байна. Заримыг нь хойшлуулчихсан гэж байгаа. Энэ тэр нь тэгээд хуульд нийцэж байгаа юу? Жишээлбэл Монросцветмет нэгдэл гээд төрийн өмчтэй компани 22.3 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн гэж. Энэ төсөвт байгууллагуудын материаллаг материалын зардлууд ер нь байнга өсөж байдаг. 3.3 их наяд төгрөг болчихсон байна.

Өнөөдөр 767 тэрбум төгрөгөөр 2022 онд нэмэгдчихэж. Энэ бусад эргэлтийн хөрөнгө гэж үзүүлэлт байдаг. Оны эхэнд энэ төсөвт байгууллагуудаар 6.1 их наяд төгрөг байснаа оны эцэст 8.6 болоод 2.4 их наяд төгрөгөөр өссөн байх юм. Энэ мөн төсөвт байгууллагуудаар урт хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 10.5 их наяд төгрөг байснаа 11.5 их наяд болон 978 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ сайн үзүүлэлт байж магадгүй гэж. Энэ ТӨК-удад хамаарах өр төлбөрийн үлдэгдэл 45.1 их наяд төгрөг байснаа 53.2 болоод 8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн өр төлбөр нь. Энэ яагаад ингэж нэмэгдэж байна? Ер нь энэ ТӨК-уд дээр ямар бодлого авч явж байна. Монгол Улсын хөгжлийн бодлого бол 1 дүгээрт тэр хувийн хэвшил дээрээ тулгуурласан энэ эдийн засгаас гадна төрийн баялаг дээрээ суурилсан энэ бодлого хосолсон ийм бодлого явах ёстой.

Ингэж байж Монгол Улс хөгжинө төсөв мөнгөтэй болно.

Тийм учраас энэ төрийн өмчтэй компаниуд дээр ямар ажлууд зохион байгуулагдаж байна. Ер нь цаашидаа ямар бодлого энэ 2022 оны төсвөөс ямар сургамж авч байна гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

2 номерын микрофон Занданбат дарга.

**Д.Занданбат:** Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан гэж бид нар Улсын Их Хуралд хүргүүлсэн. Энэ тайландаа тусгай нэг бүлэг болгож төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар тусгайлан нэг бүлэг оруулж оруулсан юм.

12 дугаар бүлэгтээ энэ талаар зааж өгсөн. Ерөнхийдөө төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээрээ төсвийг арвилан хэмнэлт үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн байна гэж аудитын байгууллага дүгнэж байгаа. Таны яг тухайлсан Төрийн хэмнэлтийн хуулиар хэмнэсэн ямар зардлууд байна гэж?

Хэмнэсэн зардлын дүн нь нийтдээ энэ дээр хэмнэлтийн бусад арга хэмжээг хэрэгжүүлсэн гээд 49.7 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна. Энэ масштабаараа хөрөнгө оруулалтын заалтыг хэрэгжүүлж 18.5 тэрбум, тээврийн хэрэгслийн хязгаарлалтыг хийснээрээ 5.1 тэрбум, албан тушаал буюу орлогч дарга нарыг чөлөөлснөөрөө 3.9 тэрбум, хэмнэлтийн зарчмыг хэрэгжүүлсэн гээд 1.7, албан томилолтын зардлыг хязгаарласан 1 тэрбум, цалин хөлсний нийтлэг жишигийг тогтоож ажилласан Төрийн хэмнэлтийн хуулиараа гээд 700 сая төгрөг.

Дүрэмт хувцасны хязгаарлалтыг хэрэгжүүлсэн гээд 100 сая төгрөг, албан тасалгааны хязгаарлалтыг хэрэгжүүлсэн гээд 100 сая төгрөг гэсэн ийм хэмнэсэн зардлын дүн нийт дүнгээрээ хэмнэлт 137

тэрбум төгрөгөөр хэмнэгдсэн гэсэн ийм тайланд дурдаж өгсөн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахад бас энэ хууль өөрөө шинэ хууль байсан. Тийм учраас эрх зүйн зарим зохицуулалт хийх шаардлагатай байна гэдэг ийм дүгнэлтийг өгсөн.

Тухайлбал Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9.2-т энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ гэж заасан хэдий ч зарим тохиолдолд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгох нь бусад агаарын тээврийн компанийг сонгосноос зардал өндөр байна. Тийм учраас энэ заалтыг бас эргээж харах хэрэгтэй.

Төрийн хэмнэлтийн хуулийн 3.1-д заасан орон нутагт албан томилолтоор хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн ААН эс үгүй бол төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашиныг ашиглахыг хориглоно гэж заасан боловч зарим чиглэлд төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллага үйлчилдэггүй хувийн хэвшлийн ААН-ээр үйлчлүүлэх боломжгүй байна. Цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг худалдан авахыг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно гэж заасан боловч цахим дэлгүүрт байгаа бараа бүтээгдэхүүн нь зах зээлийн үнээс өндөр байгаа асуудал гэсэн ийм зүйлүүд амьдрал дээр гарч ирсэн учраас энэ хуулиудынхаа зохих зохицуулалтыг бас эргээж харах шаардлагатай байна гэсэн. Ерөнхийдөө ийм дүгнэлтийг өгсөн байгаа.

Тухайлан энэнтэй нарийвчлан танилцах юм бол 11 дүгээр бүлэгт бүлэг болгож оруулсан байгаа.

**Б.Баттөмөр:** Төрийн өмчийн компаниудын менежменттэй холбоотой

энэ өр авлага нэмэгдсэнтэй холбоотой ямар учир шалтгаанууд байв? Энийг хэн хариулах юм?

Энэ чинь 8 их наяд төгрөгөөр нэмэгдчихсэн байна шүү дээ.

Монгол Улсын төсөв чинь төсвийн орлого чинь 17 их наяд төгрөг шүү дээ 2022 оны. Тэгтэл ТӨК-удын өр 8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Хэн хариулах вэ? Сангийн яамны ТНБД Ганбат. 4 номерын микрофон.

**Ж.Ганбат:** Баттөмөр гишүүний асуултад хариулья.

Засгийн газар дээр 2022 оны төсөв батлагдахаас эхлэн ТӨК-удыг менежментийг нь сайжруулах өр төлбөрийг нь барагдуулах үйл ажиллагааг нь сайжруулах үр ашгийг нь нэмэгдүүлэх чиглэлээр хэд хэдэн удаагийн шийдвэр Засгийн газрын түвшинд гаргасан байгаа. Энэ хүрээндээ ТӨК-удын өр үүсгэхгүй байх талд нь онцгой анхаараад ТӨК-уд зайлшгүй тохиолдолд өр төлбөр, өр зээл авах тохиолдолд Сангийн яамнаас зөвшөөрөл авдаг. Өрийн тухай хуулийн зохицуулалттай нь уялдуулах, Засгийн газрын өрийг нэмэгдүүлэхгүй байх. Үр ашиг гэдэг талаас нь ингэж зөвшөөрөл авч ингэж ажиллаж байгаа. Нөгөө талдаа өр төлбөрөөс гадна төрийн өмчийн компаниудын бие даасан хөрөнгө оруулалтын асуудлуудыг нь цэгцлэх тал дээр нь нэлээн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ийм байгаа. Тэгээд Засгийн газар дээр хэд хэдэн шийдвэрүүд гарсны нэг нь Засгийн газраас ямар нэгэн өр төлбөр үүсгэж урьдчилгаа төлбөр авах байдлаар өр үүсгэх байдлыг нь зогсоосон байгаа.

Тэгээд нөгөө талдаа ТӨК-удын гүйцэтгэх удирдлагуудтай байгуулах гэрээг нэг жилээр байгуулж дүгнэдэг хэрэгжилт дээр нь хяналт тавьдаг энэ тогтолцоог нь бүрдүүлээд Төрийн өмчийн хороон дээр энэ төрлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд ингэж

ажиллаж байгаа. Мэдээж яах вэ өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр төлбөрүүд бол их хэмжээтэй байгаа. Энэ өр төлбөрүүдийг бол богино хугацаанд бууруулах талаар менежментийг нь Төрийн өмчийн хорооноос болон Засгийн газраас төрийн өмчийн бүх компаниудад үүрэг даалгаврууд хугацаатай биелэлтийг нь гаргуулаад ингэж ажиллаж байгаа.

Зөвхөн Эрдэнэс Тавантолгой компани дээр 4.2 их наядын өр төлбөр байсан. Энэ дээрээ 1.5, 1.6 их наядар өр төлбөр нь буураад ийм үр дүнтэй ажиллаад явж байгаа гэсэн ийм байгаа. Ер нь бол цаашид ТӨК-удын бие даасан байдал хариуцлагыг сайжруулах, шилэн болгох энэ талд нь онцгой анхаарч ажиллаж байгаа.

**Б.Баттөмөр:** Гишүүд асуулт асууж хариулт авлаа. Үг хэлэх гишүүд байна уу?

Би үг хэлье. Энэ гүйцэтгэлд суурилсан төсөв гээд ингээд бид ярьдаг шүү дээ. Тэгээд энэ 2022 оны төсвийн энэ гүйцэтгэлээс бид их том сургамж авах ёстой. Энд бол ноцтой ноцтой тоонууд байна. Сая асуусан Монгол Улсын төсвийн орлого 17ны их наяд төгрөг байдаг. Төрийн өмчийн компаниуд нь 8 их наяд төгрөгийн өр нэмэгдүүлчихсэн байж байдаг. Эдийн засаг 4.8 хувиар өссөн гэж байгаа энэ дотор бүтээмжийн өсөлт тэг байгаа шүү дээ. Үнийн өсөлтөөр нөгөө нэмэгдсэн өртгөөр бий болсон нь өсөлт гэдэг юм бол харьцангуй бага. Бүтээмжийн өсөлт бага. Ийм байдалтай байгаа. Яах вэ ер нь хэмнэлтийн хууль бол яах вэ дөнгөж эхэлж гарч байгаа ч гэсэн бас үр дүнгээ өгсөн байна. 137 тэрбум төгрөгөөр хэмнэлт гаргасан байна. Энэ бол тийм чамлахаар чанга атга гэж. Гэхдээ сүүлийн үед энэ Хэмнэлтийн хууль чинь бас жсоохон дуу чимээ нь алга болчихлоо шүү. Эхлээд их сүртэй гараад л баахан машин тэрэг яагаад л баахан орлогч нарыг цомхотгоод байсан. Монгол Улс чинь цахим болж байна гээд л өдөр болгон л нэг цахим төв нээгээд байгаа шүү



дээ. Энэтэй холбогдуулаад энэ орон тоо илүү орон тоогоо хэмнэх барих энэ чиглэлийн юмнуудаа уг нь л үргэлжлүүлээд л хийх ёстой шүү дээ. Энэ дээр их сайн анхаарч өгөх ийм шаардлага өссөн байна л даа. Энэ эд нар дээр анхаарах ийм шаардлага байна гэдгийг би хэлье гэж ингэж бодож байна.

Ер нь ТӨК-удын энэ менежментийн засаглалыг сайжруулах чиглэлд блд онцгой анхаарах шаардлагатай. Бүр онцгой анхаарах шаардлагатай шүү. Энэ дээр маш их боломжууд байгаа.

Ялангуяа Монросцветмет нэгдэл гэдэг чинь энэ дээр маш их олон лицензүүд байж байдаг. Тэрний ашиглалт гэдэг юм байхгүй. Үр дүн муутай 2022 онд энэ байгалийн баялгаа ашиглаж бид нар юу хийв. Оюу Толгойн гэрээнд бол өөрчлөлт хийсэн. Өөр нэг дорвитой юм байхгүй байгаа шүү дээ. Гэтэл нөгөө их баялаг байна гэдэг. Баялгаараа эхний есөд ороод байна гэж байдаг. Баялгаа яагаад эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байгаа юм. Маш их олон асуудлууд байна шүү дээ. Бидэнд энэ хөгжлийн бодлого гэдэг юман дээрээ бид анхаарах шаардлагатай.

Бид нар өнөөдөр нөгөө нэг либерал бодлого л яриад байгаа шүү дээ. Хувийн хэвшилээ бүгдийг нь дэмжээд л ингээд яваад. Хувийн хэвшилээ дэмжихийн хажуугаар энэ төрийн өмчтэй энэ компаниудын үр ашгийг дээшлүүлэх газрын баялагтаа менежмент хийх,

хөрөнгө оруулалт хийх өөрөөр хэлбэл хөгжлийн тийм хосолсон загвар, хурдтай хосолсон загвар хуримтлалтай ийм загварыг л бид нар ажил болгох ёстой шүү дээ.

Тэгээд энэ тэр дээрээ ингээд анхаарч ажиллана биз дээ. Тэгээд яривал маш их олон асуудал байна. Ярих цаг хугацаа алга байна.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна.

Энэ байнгын хороогоор хэлэлцсэн нь Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал дүгнэлт гарна.

Санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ. Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд санал, дүгнэлтийг хүргүүлье ээ. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа.

Хуралд оролцсон та бүхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШНЖЭЭЧ П.МЯДАГМАА